

ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хөвсгөл аймгийн Баянзүрх сумын ЗДТГ-ын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: ХӨА-2023/185/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:

www.audit.mn

Мөрөн сум 2023 он

Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор: А.Эрдэнэбаатар

Утас: 88883317 Цахим хаяг: erdenebaatara@audit.gov.mn

Аудитын менежер: Б.Тэгшдэлгэр

Утас: 99089114 цахим хаяг: teqshdelqerb@audit.gov.mn

Аудитор: Л.Мандахнаран

Утас: 92118277 Цахим хаяг: MandakhnaranL@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ.....	4
Асуудлыг онцолсон хэсэг	4
Аудитын гол асуудал	4
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	6
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	13
4. АУДИТЫН ТАЙЛАН.....	16
4.1 Ерөнхий зүйл.....	16
4.2 Материаллаг байдал	16
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	16
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	17
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	17
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	17
4.5.1 Завсрын аудитын талаар	17
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	18
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ.....	18
5.3 Зөвлөмж.....	18
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ.....	19

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал



ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

АЗДТГ-ын байр, А корпус 3 давхар,
Мөрөн сум, Хөвсгөл аймаг, 67120
Утас/факс: 7038 3793, Цахим шуудан: khuvsgul@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

2023.02.24 № 01/177
танай _____-ны № _____-т

БАЯНЗҮРХ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА
М.БАТТУЛГА ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Баянзүрх сумын ЗДТГ-ын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Баянзүрх сумын ЗДТГ-ын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Тайланд онд аймгийн орон нутгийн төсвийн хөрөнгөөс 149,800.0 мянган төгрөг, сумын орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаас 46,000.0 мянган төгрөг нийт 195,800.0 мянган төгрөгийн хөрөнгийг хүлээн авсан байна.

Аудитын гол асуудал

Байгууллагын хөрөнгийн бүртгэлд элэгдлээрээ өртгөө нөхөж 0 үлдэгдэлтэй болсон нийт 217,886.9 мянган төгрөгийн анхны өртөгтэй 51 ширхэг хөрөнгө байна.

Бусад асуудлын хэсэг

Баянзүрх сумын Засаг даргын Тамгын газар нь тайлант онд хэрэгжүүлэхээр нийт 5 зорилт, 32 арга хэмжээг төлөвлөж 92.4 хувь хэрэгжүүлж ажилласан байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



А. ЭРДЭНЭБААТАР

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>27,581,035.28</u>	<u>27,243,767.28</u>
35	БАРАА МАТЕРИАЛ	27,581,035.28	27,243,767.28
354	Хангамжийн материал	27,581,035.28	27,243,767.28
35410	Бичиг хэргийн материал	1,829,842.00	1,829,842.00
35420	Аж ахуйн материал	13,647,425.28	13,647,425.28
35440	Түлш, шатах тослох материал	12,103,768.00	11,766,500.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>3,618,194,624.18</u>	<u>3,675,902,288.01</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	3,618,194,624.18	3,675,902,288.01
391	Газар	00.00	00.00
392	Биет хөрөнгө	3,591,287,124.18	3,649,201,537.99
39201	Барилга, байгууламж, орон сууц	3,727,246,707.73	3,798,632,065.23
39202	Хуримтлагдсан элэгдэл	-304,326,062.87	-506,400,592.13
39203	Авто-тээврийн хэрэгсэл	239,939,000.00	435,739,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-186,742,901.25	-210,910,034.62
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	120,354,993.50	146,020,025.50
39206	Хуримтлагдсан элэгдэл	-29,093,787.66	-43,192,100.02
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	26,338,510.00	26,338,510.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-7,179,335.28	-10,085,336.00
39214	Бусад үндсэн хөрөнгө	5,000,000.00	14,800,000.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-249,999.99	-1,739,999.97
393	Биет бус хөрөнгө	26,907,500.00	26,700,750.02
39301	Програм хангамж	2,605,000.00	2,605,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-1,587,500.00	-1,794,249.98
39303	Бусад биет бус хөрөнгө	25,890,000.00	25,890,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>3,645,775,659.46</u>	<u>3,703,146,055.29</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>550,000.00</u>	<u>00.00</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	550,000.00	00.00
413	Өглөг	550,000.00	00.00
4136	Бусад өглөг	550,000.00	00.00
41361	Байгууллагад төлөх өглөг	550,000.00	00.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>3,645,225,659.46</u>	<u>3,703,146,055.29</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	3,645,225,659.46	3,703,146,055.29
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	327,386,920.40	327,386,920.40
51101	Өмч: - төрийн	327,386,920.40	327,386,920.40
512	Хуримтлагдсан үр дүн	2,795,260,749.49	2,853,181,145.32
51210	Өмнөх үеийн үр дүн	2,795,260,749.49	2,795,810,749.49
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	57,370,395.83
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>3,645,775,659.46</u>	<u>3,703,146,055.29</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	2,210,619,945.49	734,118,789.50
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,811,926,207.49	295,821,389.50
120	Нийтлэг татварын бус орлого	1,802,611,207.49	295,821,389.50
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	1,802,611,207.49	295,821,389.50
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	484,000.00	540,000.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	1,802,127,207.49	295,281,389.50
122	Тусламжийн орлого	9,315,000.00	00.00
122001	Хандив тусламж /дотоод/	9,315,000.00	00.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	398,693,738.00	438,297,400.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	10,081,938.00	4,466,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	10,081,938.00	4,466,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	388,611,800.00	433,831,400.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	388,611,800.00	433,831,400.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	588,215,141.33	676,748,393.67
21	УРСГАЛ ЗАРДАЛ	588,215,141.33	676,748,393.67
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	585,168,241.33	649,231,893.67
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	260,768,100.00	272,067,400.00
210101	Үндсэн цалин	258,368,100.00	218,886,484.69
210102	Нэмэгдэл	00.00	39,031,017.31
210104	Урамшуулал	2,400,000.00	14,149,898.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	32,296,000.00	34,839,400.00
210201	Тэтгэврийн даатгал	21,961,300.00	23,677,200.00
210202	Тэтгэмжийн даатгал	2,583,600.00	2,805,600.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,037,000.00	2,228,400.00
210204	Ажилгүйдлийн даатгал	546,700.00	557,100.00
210205	Эрүүл мэндийн даатгал	5,167,400.00	5,571,100.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	15,056,232.00	23,653,568.00
210301	Гэрэл, цахилгаан	6,896,840.00	6,439,800.00
210302	Түлш, халаалт	8,159,392.00	17,213,768.00
2104	Хангамж, бараа материалын зардал	31,707,102.00	28,786,600.00
210401	Бичиг хэрэг	4,189,000.00	4,866,000.00
210402	Тээвэр, шатахуун	23,676,102.00	20,950,600.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,430,000.00	2,670,000.00
210404	Ном, хэвлэл	492,000.00	300,000.00
210408	Бараа материал акталсны зардал	920,000.00	00.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,000,000.00	3,809,600.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	00.00	117,900.00

210604	Урсгал засвар	2,000,000.00	3,691,700.00
2107	Томилолт, зочны зардал	3,126,600.00	2,370,000.00
210702	Дотоод албан томилолт	3,126,600.00	2,370,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	25,700,136.00	26,945,740.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	24,647,736.00	25,895,740.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	00.00	450,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	163,900.00	160,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	85,500.00	90,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	00.00	50,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	700,000.00	300,000.00
210807	Газрын төлбөр	103,000.00	00.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	214,514,071.33	256,759,585.67
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	21,137,900.00	9,979,360.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,200,000.00	1,837,500.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	192,176,171.33	244,942,725.67
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	3,046,900.00	27,516,500.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	3,046,900.00	27,516,500.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	00.00	22,650,600.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	3,046,900.00	4,865,900.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	1,622,404,804.16	57,370,395.83
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	82,786,069.62	00.00
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	82,786,069.62	00.00
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-82,786,069.62	00.00
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	1,539,618,734.54	57,370,395.83

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	408,492,738.00	438,837,400.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	9,799,000.00	540,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	484,000.00	540,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	484,000.00	540,000.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	484,000.00	540,000.00
122	Тусламжийн орлого	9,315,000.00	00.00
122001	Хандив тусламж /дотоод/	9,315,000.00	00.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	398,693,738.00	438,297,400.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	10,081,938.00	4,466,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	10,081,938.00	4,466,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	388,611,800.00	433,831,400.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	388,611,800.00	433,831,400.00

2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	403,502,738.00	431,468,400.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	403,502,738.00	431,468,400.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	400,455,838.00	403,951,900.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	260,768,100.00	272,067,400.00
210101	Үндсэн цалин	258,368,100.00	218,886,484.69
210102	Нэмэгдэл	00.00	39,031,017.31
210104	Урамшуулал	2,400,000.00	14,149,898.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	32,296,000.00	34,839,400.00
210201	Тэтгэврийн даатгал	21,961,300.00	23,677,200.00
210202	Тэтгэмжийн даатгал	2,583,600.00	2,805,600.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,037,000.00	2,228,400.00
210204	Ажилгүйдлийн даатгал	546,700.00	557,100.00
210205	Эрүүл мэндийн даатгал	5,167,400.00	5,571,100.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	21,700,000.00	23,316,300.00
210301	Гэрэл, цахилгаан	6,896,840.00	6,439,800.00
210302	Түлш, халаалт	14,803,160.00	16,876,500.00
2104	Хангамж, бараа материалын зардал	29,787,102.00	28,786,600.00
210401	Бичиг хэрэг	4,189,000.00	4,866,000.00
210402	Тээвэр, шатахуун	22,676,102.00	20,950,600.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,430,000.00	2,670,000.00
210404	Ном, хэвлэл	492,000.00	300,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	4,740,000.00	3,809,600.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	00.00	117,900.00
210604	Урсгал засвар	4,740,000.00	3,691,700.00
2107	Томилолт, зочны зардал	3,126,600.00	2,370,000.00
210702	Дотоод албан томилолт	3,126,600.00	2,370,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	25,700,136.00	26,945,900.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	24,647,736.00	25,895,900.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	00.00	450,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	163,900.00	160,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	85,500.00	90,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	00.00	50,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	700,000.00	300,000.00
210807	Газрын төлбөр	103,000.00	00.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	22,337,900.00	11,816,700.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	21,137,900.00	9,979,200.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,200,000.00	1,837,500.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	3,046,900.00	27,516,500.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	3,046,900.00	27,516,500.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	00.00	22,650,600.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	3,046,900.00	4,865,900.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	4,990,000.00	7,369,000.00

5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	4,990,000.00	7,369,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	4,990,000.00	7,369,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	4,990,000.00	7,369,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	4,990,000.00	7,369,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	<u>-4,990,000.00</u>	<u>-7,369,000.00</u>
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	00.00	00.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	00.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	00.00

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
2021 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл	327,386,920.40	522,777,973.57	1,255,442,030.95	2,105,606,924.92
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	199,984.00	199,984.00
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	327,386,920.40	522,777,973.57	1,255,642,014.95	2,105,806,908.92
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	00.00	00.00	00.00	00.00
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	00.00	00.00	00.00	00.00
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00
Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	1,539,618,734.54	1,539,618,734.54
2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	327,386,920.40	522,577,989.57	2,795,260,749.49	3,645,225,659.46
2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	327,386,920.40	522,577,989.57	2,795,260,749.49	3,645,225,659.46
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	550,000.00	550,000.00
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	327,386,920.40	522,577,989.57	2,795,810,749.49	3,645,775,659.46
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00
Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00
Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	00.00	00.00	00.00	00.00
Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	57,370,395.83	57,370,395.83
2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	327,386,920.40	522,577,989.57	2,853,181,145.32	3,703,146,055.29

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	0.00	0.00
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	433,831,400.00	433,831,400.00	0.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	433,831,400.00	433,831,400.00	0.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	406,764,900.00	406,764,900.00	0.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	269,967,400.00	269,967,400.00	0.00
210101	Үндсэн цалин	269,967,400.00	218,886,484.69	51,080,915.31
210102	Нэмэгдэл	00.00	39,031,017.31	-39,031,017.31
210104	Урамшуулал	00.00	12,049,898.00	-12,049,898.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	34,839,400.00	34,839,400.00	0.00
210201	Тэтгэврийн даатгал	23,677,200.00	23,677,200.00	0.00
210202	Тэтгэмжийн даатгал	2,805,600.00	2,805,600.00	0.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,228,400.00	2,228,400.00	0.00
210204	Ажилгүйдлийн даатгал	557,100.00	557,100.00	0.00
210205	Эрүүл мэндийн даатгал	5,571,100.00	5,571,100.00	0.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	23,316,300.00	23,316,300.00	0.00
210301	Гэрэл, цахилгаан	8,196,300.00	6,439,800.00	1,756,500.00
210302	Түлш, халаалт	15,120,000.00	16,876,500.00	-1,756,500.00
2104	Хангамж, бараа материалын зардал	26,630,600.00	26,630,600.00	0.00
210401	Бичиг хэрэг	4,099,100.00	4,326,000.00	-226,900.00
210402	Тээвэр, шатахуун	19,491,500.00	19,364,600.00	126,900.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,640,000.00	2,640,000.00	0.00
210404	Ном, хэвлэл	400,000.00	300,000.00	100,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	9,198,600.00	9,198,600.00	0.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	5,506,900.00	5,506,900.00	0.00
210604	Урсгал засвар	3,691,700.00	3,691,700.00	0.00
2107	Томилолт, зочны зардал	2,370,000.00	2,370,000.00	0.00
210702	Дотоод албан томилолт	2,370,000.00	2,370,000.00	0.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	28,925,900.00	28,925,900.00	0.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	27,875,900.00	27,875,900.00	0.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	450,000.00	450,000.00	0.00
210803	Даатгалын үйлчилгээ	160,000.00	160,000.00	0.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	90,000.00	90,000.00	0.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	50,000.00	50,000.00	0.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	300,000.00	300,000.00	0.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	11,516,700.00	11,516,700.00	0.00

210901	Бараа үйлчилгээний бусад зардал	9,679,200.00	9,679,200.00	0.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,837,500.00	1,837,500.00	0.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	27,066,500.00	27,066,500.00	0.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	27,066,500.00	27,066,500.00	0.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	22,650,600.00	22,650,600.00	0.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	4,415,900.00	4,415,900.00	0.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	433,831,400.00	433,831,400.00	0.00
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	433,831,400.00	433,831,400.00	0.00
132001	Орон нутгийн төсвөөс	433,831,400.00	433,831,400.00	0.00
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	00.00	0.00
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	00.00	0.00
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	26.00	26.00	0.00
620001	Удирдах ажилтан	03.00	03.00	0.00
620002	Гүйцэтгэх ажилтан	17.00	17.00	0.00
620003	Үйлчлэх ажилтан	06.00	06.00	0.00

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	5,006,000.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	5,006,000.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	4,556,000.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	2,100,000.00
210104	Урамшуулал	2,100,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	2,156,000.00
210401	Бичиг хэрэг	540,000.00
210402	Тээвэр, шатахуун	1,586,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	30,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	300,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	300,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	450,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	450,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	450,000.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	5,006,000.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	5,006,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	4,466,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	540,000.00
IV	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)-(II)-(I)	0.00
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Байгууллагын үйл ажиллагааны чиглэл, зорилго, зорилтын талаар: Баянзүрх сумын ЗДТГ нь тухайн орон нутагт хууль журамд заасан чиг үүрийг орон нутагт хэрэгжүүлэх, ард иргэдийг мэдээллээр хангах үндсэн чиг үүрэгтэй ажиллаж байна. 2022 онд “Төрийн үйлчилгээг иргэдэд түргэн шуурхай хүргэх замаар, сумын эдийн засаг нийгмийн хөгжлийг хангах” гэсэн зорилго тавьж, түүнийгээ биелүүлэхийн тулд дараах зорилтуудыг дэвшүүлэн ажилласан байна. Үүнд:

1. Хүний хөгжлийн бодлого
2. Эдийн засгийн бодлого
3. Засаглалын бодлого
4. Ногоон хөгжлийн бодлого
5. Сум орон нутгийн хөгжлийн бодлого

ЗДТГ-ын дарга нь нь сумын Засаг даргатай 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө байгуулж, түүнийг 92.4 хувиар биелүүлж ажилласан байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй хууль эрх зүйн орчны талаар:

Тус байгууллага нь Төсвийн тухай хууль, Хувь хүний орлогын албан татварын тухай хууль, нийгмийн даатгалын шимтгэлийн тухай хууль, Засаг захиргаа нутаг дэвсгэрийн тухай хууль болон бусад хууль тогтоомж журам зааврыг мөрдөн ажилласан байна. Тайлант онд Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжсэнтэй холбоотой байгууллагын үйл ажиллагаанд хэмнэлтийн горимыг баримталж ажилласан байна.

Байгууллагын дотоод хяналтын талаар:

Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолоор баталсан Аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам"-ийн дагуу цэцэрлэгийн эрхлэгчийн 2022 оны 09 сарын 21 өдрийн А/17 тоот тушаалаар дотоод хяналт хэрэгжүүлэх ажлын хэсгийг 3 хүний бүрэлдэхүүнтэй баталсан байна.

Дотоод хяналтын ажлын хэсэг нь 2022 онд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө батлуулан, тухайн онд нийт 2 удаа дотоод хяналтыг хэрэгжүүлсэн байна. Дотоод хяналтаар илэрсэн зөрчлийг тухай бүр арилгаж ажилласан байна.

Харин санхүүгийн үйл ажиллагаанд дотоод хяналтын 2 үе шатны тогтолцоо бий болсон байна гэж үзлээ. **Тухайлбал:** Санхүүгийн үйл ажиллагаанд гүйцэтгэх удирдлага буюу Засаг даргын Тамгын газрын дарга 1 дүгээр гарын үсэг, нягтлан бодогч 2 дугаар гарын үсэг зурж баталгаажуулж гүйцэтгэх удирдлагын хяналтыг хэрэгжүүлж байна. Мөн сумын Төрийн сангийн мэргэжилтэн гүйлгээ тус бүрээр хяналт хийж, санхүүгийн албаны дарга гүйлгээг баталж байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна гэж үзлээ.

Тайлант онд дээд шатны төсвийн захирагчийн дотоод аудитын чиг үүрэг хэрэгжүүлэх нэгжээс хяналтыг хэрэгжүүлээгүй тул аудитад ашиглах дотоод аудитын гүйцэтгэл, ажлын үр дүнгийн тайлан зэрэг баримт материал байхгүй байна.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Баянзүрх сумын ЗДТГ-ын 2022 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэж, Төсвийн тухай хуулийн 54.4, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлд заасан иж бүрдийн дагуу бэлтгэж толилуулсан байна гэж үзлээ.

Харин төсвийн гүйцэтгэлийн тайланг мөнгөн сууриар бэлтгэж, Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.5 дахь заалтад заасан заалтын дагуу иж бүрэн ирүүлсэн.

Байгууллагын мөрдөж буй нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн талаар: Санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаандаа Хөвсгөл аймгийн Засаг даргын 2019 оны А/375 дугаар захирамжаар баталсан "Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг"-ийг үйл ажиллагаандаа ашиглаж байна. Тус Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт тусгагдсан зарим журам заавар шинэчлэгдсэн, боловсролын салбарын байгууллагуудын төсвийн шатлалд өөрчлөлт орсонтой холбоотой нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг өөрийн байгууллагын үйл ажиллагаандаа тохируулан боловсруулах шаардлага тулгарч байна.

Гэхдээ санхүү, төсөв нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаандаа УСНББОУС, Засгийн газар, Сангийн яамнаас гаргасан журам, зааврыг мөрдөж ажилласан байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Баянзүрх сумын ЗДТГ-ын 2022 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан "Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар"-ын дагуу бэлтгэсэн байна. Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 57,370.4 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/мянган төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б			
Мөнгөн хөрөнгө	0.0	0.0	0.0
Авлага	0.0	0.0	0.0
Бараа материал	27,581.0	27,243.7	-337.3
Үндсэн хөрөнгө	3,618,194.6	3,675,902.3	57,707.7
Нийт хөрөнгө	3,645,775.6	3,703,146.0	57,370.4
Өр төлбөр	550.0	0	-550.0
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	3,645,225.7	3,703,146.1	57,920.4
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	3,645,775.6	3,703,146.0	57,370.4

Дээрх хүснэгтээс харахад үндсэн хөрөнгө данс өмнөх оноос нэмэгдэж, өр төлбөр данс буурсан үзүүлэлттэй байна. Үүнд:

1. Үндсэн хөрөнгө данс 57,707.7 мянган төгрөгөөр өссөн нь аймаг, сумын ОНХС-ийн хөрөнгө оруулалт, хандиваар хүлээн авсан 302,650.4 мянган төгрөгийн хөрөнгийн орлого болон тайлант оны нийт элэгдлийн зардал болох 244,942.7 мянган төгрөгийн хоорондох зөрүү дүн байна.

2. Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар Ханна ундарга ХХК төлөх 550.0 мянган төгрөгийн өр төлбөрийг барагдуулах албан шаардлагыг хэрэгжүүлж ажилласны үр дүнд тайланд онд өр төлбөрийн данс үлдэгдэлгүй болсон байна.
3. Байгууллагын хөрөнгийн бүртгэлд элэгдлээрээ өртгөө нөхөж 0 үлдэгдэлтэй болсон нийт 217,886.9 мянган төгрөгийн анхны өртөгтэй 51 ширхэг хөрөнгө байна.
Дээрх хөрөнгүүдийг цаашид ашиглах хугацааг тодорхойлж үнэлэх зөвлөмж хүргүүлэв.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Баянзүрх сумын ЗДТГ нь 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг орон нутгийн төсвөөс 462,604.6 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Баянзүрх сумын ИТХ-ын 2021 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн ээлжит 5 дугаар хуралдаанаар төсвийн төслийн саналаас орон нутгийн төсвөөр санхүүжүүлэх дүнг 54,608.4 мянган төгрөгөөр бууруулан 2 хөтөлбөрийн 8 арга хэмжээг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр 407,996.2 мянган төгрөгөөр баталсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Баянзүрх сумын ИТХ-ын 2022 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн ээлжит бус 8 дугаар хуралдаанаар тус байгууллагын төсөвт тодотгол хийж төсвийг 25,835.2 мянган төгрөгөөр нэмэгдүүлж 433,831.4 мянган төгрөгөөр баталсан байна.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 433,831.4 мянган төгрөгийн санхүүжилт хүлээн авч батлагдсан төсвийн дагуу зарцуулж, нийт зардлын гүйцэтгэл 433,831.4 мянган төгрөг буюу 100 хувьтай байна.

Тайлант онд 2 хөтөлбөрийн хүрээнд 8 арга хэмжээг хэрэгжүүлсэн байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

Хөтөлбөр	Арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	/мянган төгрөгөөр/	
				Зөрүү	Биелэлт
70106 Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага,	80101-Үндсэн үйл ажиллагаа	279,414.6	279,414.6	0	100
	80106- Баг хорооны үйл ажиллагаа	55,350.0	55,350.0	0	100
	80112-Нийтлэг үйлчилгээ	41,124.0	41,124.0	0	100
	80802-Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал, дэмжлэг	4,415.9	4,415.9	0	100
	80815- Сонгуулийн үр дүнгээр чөлөөлөгдсөн албан хаагчид олгох тэтгэмж	22,650.6	22,650.6	0	100
	82801-Улсын их баяр наадам	3,000.0	3,000.0	0	100
	81102-Орон нутгийн нөөц хөрөнгө	15,000.0	15,000.0	0	100
71413 Байгаль орчин хамгаалан нөхөн сэргээх,	81701-Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх	12,875.9	12,875.9	0	100

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Баянзүрх сумын ЗДТГ нь 2022 онд нэмэлт санхүүжилтээр мал тооллогын ажлын санхүүжилт 3,716.0 мянган төгрөг, тендерийн баримт бичгийн орлого 540.0 мянган төгрөг, аймгийн ИТХ-аас хамтарсан багийн үйл ажиллагааны санхүүжилт 300.0 мянган төгрөг, нийт 5,006.0 мянган төгрөгийг төвлөрүүлсэн байна. Дээрх санхүүжилтийн орлогыг баталсан удирдамж, зориулалтын дагуу зарцуулалтын эрх нээлгэж зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

2022 онд гадаад, дотоодын эх үүсвэрээр ямар нэгэн төсөл хөтөлбөр хэрэгжээгүй байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Баянзүрх сумын ЗДТГ-ын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулахтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Л.Мандахнаран гүйцэтгэж, аудитын менежер Б.Тэгшдэлгэр анхан шатанд хянаж, тэргүүлэх аудитор А.Эрдэнэбаатар дараагийн шатны хяналтыг хэрэгжүүлсэн.

Баянзүрх сумын ЗДТГ-ын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг 2023 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн 3/20 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 588,215.1 мянган төгрөгөөс 2 хувиар буюу 8,823.2 мянган төгрөгөөр, тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох “шаардлагагүй” гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн авч хэрэгжүүлэх арга хэмжээний нийт 29 асуудлаар хяналтыг хэрэгжүүлэхэд дараах зөрчил илэрлээ. Үүнд:

1. Байгууллагын төсвөөс тус сумын Санхүү албаны дарга А.Дэлгэрмаагийн 86410103 дугаарын интернэтийн төлбөр болох 25.0 мянган төгрөг, Шишгэд бүсийн тэмцээнд оролцсон хүмүүсийн хоолны зардал болох 232.0 мянган төгрөг, нийт 257.0 мянган төгрөгийг төлсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоов

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Баянзүрх сумын ЗДТГ-ын 2022 оны шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд тавьсан мэдээллээс дараах мэдээллийг түүвэрлэн хянаж үзлээ. Үүнд:

- Тендерт шалгарсан болон шалгараагүй оролцогчийн талаарх товч мэдээлэл
- Цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш орлого, зардлын гүйлгээ
- Төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах шийдвэрийн мэдээлэл

Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд тавьсан мэдээллийг хянаж үзэхэд дараах зөрчил илэрсэн болно. Үүнд:

- Цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш орлого, зардлын нийт 455,907.2 мянган төгрөгийн 17 гүйлгээ мэдээлэхээс нийт 22,075.8 мянган төгрөгийн 4 зарлагын гүйлгээг мэдээлээгүй, 34,963.7 мянган төгрөгийн 1 орлогын гүйлгээг мэдээлээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Зөвлөмж хүргүүлсэн

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

2022 онд шинээр хэрэгжиж эхэлсэн журам заавруудын хэрэгжилтийг хянаж үзэхэд зөрчилтэй асуудал илрээгүй болно.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Баянзүрх сумын ЗДТГ-ын 2022 оны санхүүгийн үйл ажиллагаанд завсрын аудит хэрэгжүүлээгүй болно.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар тогтоосон 1 төлбөрийн акт, 1 албан шаардлага, 1 зөвлөмж хүргүүлснийг 100 хувь хэрэгжүүлж ажилласан байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	1	170.7	1	170.7	100
Албан шаардлага	1	550.0	1	550.0	100
Зөвлөмж	1	1547.1	1	1547.1	100
Нийт дүн	3	2,267.8	3	2,267.8	100

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарал хандуулах асуудал байхгүй байна.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар санхүүгийн тайлангийн толилуулгыг илэрхийлэхдээ нягтлан бодох бүртгэлээс зөрүүтэй илэрхийлсэн байсныг аудитын хугацаанд залруулсан болно.

Санхүүгийн тайлангийн аудитаар нийт 257.0 мянган төгрөгийн зөрчил¹ илрүүлж, 257.0 төгрөгийн 1 төлбөрийн акт тогтоож дахин давтахгүй байх 1 зөвлөмж өгсөн.

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудлаар нийт 57,093.5 мянган төгрөгийн зөрчил илрүүлж дахин давтахгүй байх 1 зөвлөмж өгсөн.

5.1 Төлбөрийн акт

Илрүүлэлт:

1. Байгууллагын төсвөөс тус сумын Санхүү албаны дарга А.Дэлгэрмаагийн 86410103 дугаарын интернэтийн төлбөр болох 25.0 төгрөг, бүсийн тэмцээнд оролцсон хүмүүсийн хоолны зардал болох 232.0 төгрөг, нийт 257.0 төгрөгийг төлсөн байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь "Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаалаар баталсан "Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар", "Төрийн хэмнэлтийн тухай хууль"-ийн 12 дугаар зүйлийн 12.1 дэх "Энэ хуулийн 3.1-д заасан этгээдэд дараах зориулалтаар зардал санхүүжүүлэх, зарцуулахыг хориглоно", 12.1.1 дэх "гар утасны зардал", 15 дугаар зүйлийн 15.1.3 дахь "хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох" заалттай тус тус нийцэхгүй байна.

5.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой асуудал

Илрүүлэлт:

1. Цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш орлого, зардлын нийт 455,907.2 мянган төгрөгийн 17 гүйлгээ мэдээлэхээс нийт 22,075.8 мянган төгрөгийн 4 зарлагын гүйлгээг мэдээлээгүй, 34,963.7 мянган төгрөгийн 1 орлогын гүйлгээг мэдээлээгүй байна. Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.4, 6.4.5, дахь

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

заалттай нийцэхгүй байгаа ба “нийцсэн бөгөөд зохистой” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна

Өгсөн зөвлөмж:

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангаж, мэдээллийг тогтоосон хугацаанд нь бүрэн мэдээлж хэвших

2. Үндсэн хөрөнгөтэй холбоотой асуудал

Илрүүлэлт:

Байгууллагын хөрөнгийн бүртгэлд элэгдлээрээ өртгөө нөхөж 0 үлдэгдэлтэй болсон нийт 217,886.9 мянган төгрөгийн анхны өртөгтэй 51 ширхэг хөрөнгө байна. Энэ нь “Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль”-ийн 20 дугаар зүйлийн 20.2.6 дахь “эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх...” заалттай нийцэхгүй байгаа ба нийцсэн бөгөөд зохистой гэсэн батламж мэдэгдэл хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Дээрх хөрөнгүүдийн цаашид ашиглах хугацааг тогтоож, үнэлэх

Дээрх төлбөрийн акт, зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2023 оны 9 дүгээр сарын 20-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Зориулалт бус зарцуулалт	1	257.0	1	257.0								0
Хөрөнгийн ашиглалтын хугацаа	1	0.0					1	0.0				
Дүн	2	257.0	1	257.0			1	0.0				

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Хугацаа хоцроож мэдээлсэн	0.0	0.0						
Мэдээлээгүй	5	57,093.5	0	0	0	0	1	57,093.5
Дүн	5	57,093.5	0	0	0	0	1	57,093.5
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Норм норматив баримтлаагүй								
Дүн								
Нийт дүн	5	57,093.5	0	0	0	0	1	57,093.5

БАТАЛГААЖУУЛСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

ХЯНАСАН:

АУДИТЫН МЕНЕЖЕР

АХЛАХ АУДИТОР

БОЛОВСРУУЛСАН:

АУДИТОР



А.ЭРДЭНЭБААТАР

Б.ТЭГШДЭЛГЭР

Б.ДАВААНЯМ

Л.МАНДАХНАРАН